



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 59

Ховд

"Монгол хэл бичиг" дэд хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Бүх нийтээр хос бичигтэн болох зорилтыг хангахад чиглэсэн "Монгол хэл бичиг" дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагдах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хөренгө оруулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлэж хэрэгжилтийг ханган, үр дунг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн үр дунг жил бүр аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.



0000195

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2021 оны 59 дугаар тогтоолын
хавсралт

“МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ” ДЭД ХӨТӨЛБӨР
(2021-2024)

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол хэл нь Монгол үндэстний оюуны соёлын өв, үндэсний соёл иргэншлийн язгуур үндэс, улс орны нэгдмэл байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтолын нэгэн баталгаа бөгөөд монгол улсын иргэн бүр Монгол хэл, бичиг үсгээ сурх, Монгол хэлээр мэдээлэл авах, өвлөх, өвлүүлэх, хамгаалах, хөгжүүлэх боломж, нехцэлеер хангагдах эрхтэй бөгөөд монгол хэл, бичгээ зээмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжилтийг хангах нь Монгол төрийн үүрэг мөн.

Монгол Улсын Засгийн газраас 1995-2005 онд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр I”, 2008-2015 онд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II” хэрэгжүүлснээр ерөнхий боловсролын сургуулийн VI-IX ангид монгол бичиг хичээлийг судалж, иргэний болон боловсролын баримт бичгийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн үйлдэх, ном, сурх бичиг зохион, хөрвүүлэх, түүх, соёлын бүтээлийг нийтийн хүртээл болгох зэрэг үр дүн бий болсон боловч, “Бүх нийтэд монгол бичгийг сургах, нийтийн хэрэглээний бичиг болгох, хэрэглэх орчин бий болгох” зэрэг зорилтууд хангалтгүй хэрэгжиж иржээ.

“Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.2.2, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.8 дахь заалтууд нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс болно.

Монгол Улсын Засгийн газрын 96 тогтоолоор “Монгол бичгийн хөтөлбөр -III”-ийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд түүний 3.3.7 дахь заалтад төрийн байгууллагууд албан бичиг хэргээ 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэх хетлэх орчин бүрдүүлэх, туршиж эхлэх, Монгол хэлний тухай хуулийн 24-ийн 7.2 дахь хэсэгт 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах тухай тус заасан.

Иймд “Хос бичигтэн” болох бэлтгэл ажлыг аймгийн хэмжээнд хангах, үндэсний бичигт суралцах, мэдлэг чадвараа ахиулах, бичиг, соёлыг сурталчлан түгээн дэлгэрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага нь уг хөтөлбөрийг

хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХУГАЦАА

2.1. Монгол хэл, бичгийн сургалтын чанарыг дээшлүүлэн, үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлж, төрийн албан хэргийг 2025 оноос хос бичгээр хөтлөх явуулах бэлтгэл ажлыг аймгийн хэмжээнд хангахад оршино.

2.2.Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.

2.2.1.Монгол бичгийн орчин бүрдүүлэх;

2.2.2.Монгол бичиг сурах, сургах ажлыг эрчимжүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх

2.2.3.Албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэл хангах

2.2.4.Монгол бичгийн сургалт, сурталчилгааг өргөжүүлэн, түгээн дэлгэрүүлэх

2.2.5.Монгол хэл, бичгийн сургалтын чанарыг дээшлүүлэх

2.3 Хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3.1.Хөтөлбөрийн "Монгол бичгийн орчин бүрдүүлэх" зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.1.1.Төрийн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээнд монгол бичгийг хэрэглэх

3.1.2.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, танилцуулга, бэлгэ тэмдэг, нэрийн хуудас, зар сурталчилгаа зэргийг кирилл болон үндэсний бичгээр хослуулан алдаагүй бичих ажлыг зохион байгуулах

3.1.3.Албан байгууллагууд монгол бичгийн орчин бүрдүүлэх

3.2.Хөтөлбөрийн "Монгол бичиг сурах, сургах ажлыг эрчимжүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх" зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.1.Албан байгууллага бүр монгол бичгээ үе шаттай сурах нехцөлийг бүрдүүлэн, цахим хэрэглээг бий болгох

3.2.2.Монгол хэлний зөв бичих дүрэм, монгол бичгийн төлө хичээл явуулж, цахим сургалтыг нэмэгдүүлэх

3.2.3.Бийрийн бичвэрийн сургалтыг зохион байгуулах, дугуйлан хичээллүүлэх, үнэлэх, урамшуулах

3.2.4.Насан туршийн боловсрол төв, нэгжээр дамжуулан иргэдэд монгол бичиг заах сургалтыг үе шаттай хэрэгжүүлэх

3.3 Хөтөлбөрийн "Албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэл хангах" зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3.1. Төрийн байгууллагын бичиг хэргийн ажилтан болон орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтныг чадваржуулах

3.3.2. Монгол хэл, бичгийн зөв бичих дүрэм, журамласан үг зэргийг сайтад байршуулж нийтэд түгээх

3.4. Хөтөлбөрийн "Монгол бичгийн сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, түгээн дэлгэрүүлэх" зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.4.1. Бүх шатны Засаг дарга нар нутаг дэвсгэрийн хэмжээнд үндэсний бичиг соёлоо түгээн дэлгэрүүлэх, иргэдийг урамшуулах

3.4.2. Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд бичиг соёлоо сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх

3.4.3. Монгол хэл, бичгийн сургалт, сурталчилгааны төв байгуулах

3.5. Хөтөлбөрийн "Монгол хэл, бичгийн сургалтын чанарыг дээшлүүлэх" зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.5.1. Монгол хэл, бичиг, бага ангийн багш нарын мэргэшлийг дээшлүүлэх

3.5.2. Багш нарын шилдэг арга зүй, туршлагыг судлах, түгээн дэлгэрүүлж, сан бүрдүүлэх, урамшуулах

3.5.3. Сургалтын чанарыг дээшлүүлэхэд идэвх санаачилга гаргасан багш, сургууль, хамт олныг алдаршуулах

ДӨРӨВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Ховд аймагт үйл ажиллагаа явуулж байгаа нийт байгууллагууд /өмчийн хэлбэр харгалзахгүйгээр/, иргэд, суралцагчид

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1. Хөтөлбөрийн холбогдох заалтыг аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулах гэрээнд тусгаж ажиллана.

5.2. Хөтөлбөрийг удирдлага зохион байгуулалтаар хангах, хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хэлний бодлогын аймгийн салбар зөвлөл болон Боловсролын газар хариуцна.

5.3. Хөтөлбөрийн хүрээнд байгууллага хоорондын уялдаа холбоог хангах, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхийг Боловсролын газар зохион байгуулна.

5.4. Сумын Засаг даргын Тамгын газар нь орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангана.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

- 6.1. Улсын төсөв
- 6.2. Орон нутгийн төсөв
- 6.3. Олон улсын төсөл хөтөлбөр
- 6.4. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив
- 6.5. Бусад эх үүсвэр

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин				
						2020	2021	2022	2023	2024
Зорилт 3.1 Монгол бичгийн орчин бүрдүүлэх										
1.	3.1.1. Териин ёслол, хүндэтгэлийн арга хэмжээнд монгол бичгийг хэрэглэх,	Монгол бичгийг хэрэглээ нэмэгдэнэ. Эх хэлээ хайрлах, хамгаалах дээдлэх үзэл төлөвшине.	Териин ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд монгол бичгийг хэрэглэж буй хувь	Хувь	-	10	30	50	70	
2.	3.1.2. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, танилцуулга, бэлгэ тэмдэг, нэрийн хуудас, зар сурталчилгаа зэргийг кирилл болон үндэсний бичгээр хослуулан алдаагүй бичих ажлыг зохион байгуулах	Бүх нийтийн монгол бичгийн мэдлэг дээшилнэ. Байгууллага бүр чанарын шаардлага хангасан стандартын хаяг /том, жижиг/-тай болно.	Нэр хаяг, шошго монгол бичгээр бичиж байршуулсан байгууллагын эзлэх хувь	Хувь	5	10	30	50	70	
3.	3.1.3. Албан байгууллагууд монгол бичгийн орчин бүрдүүлэх	Монгол бичгийн хэрэглээ, орчин бүрдсэн байна. Байгууллага бүр толь бичигтэй болж, албан хэргийг чанартай хетелне.	Орчин бүрдүүлсэн байгууллагын хувь	Хувь	-	30	50	70	90	
		Монгол бичгийн өргөтэй болж, хэрэглэгдэхүүнээр хангагдсан байна.	Монгол бичгийн өргөөг баяжуулж, тохижуулсан сургуулийн эзлэх хувь	Хувь	-	-	50	100	-	
Зорилт 3.2. Монгол бичиг сурх, сургах ажлыг эрчимжүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх										
4.	3.2.1. Албан байгууллага бүр монгол бичгээ үе шаттай сурх, сургах ажлыг бүрдүүлэн, цахим хэрэглээг бий болгох	Албан хаагчдын монгол хэл, бичгийн унших бичих чадвар дээшилсэн, кирилл бичгээрээ алдаагүй бичдэг болно. Цахим	Монгол бичгийн сургалтад хамрагдсан албан хаагчийн эзлэх хувь	Хувь	-	40	70	90	100	

		бичвэрийн хэрэглээ нэмэгдэнэ.							
5.	3.2.2.Монгол хэлний зөв бичих дүрэм, монгол бичгийн төле хичээл явуулж, цахим сургалтыг нэмэгдүүлэх	Нийт иргэдийн кирилл бичгээр алдаагүй бичих чадвар дээшилж, монгол бичгээ сурах сэдэл тэмүүлэл бий болж, сурах боломж нөхцөл бүрдэнэ.	Теле хичээлийн тоо	Too	-	-	90	-	-
6.	3.2.3.Бийрийн бичвэрийн сургалт зохион байгуулах, дугуйлан хичээллүүлэх, үнэлэх, урамшуулах	Өв соёлоороо бахархан, бүтээлийн үзэсгэлэн гаргаж, олон нийтэд сурталчилсан байна.	Сургалтад хамрагдсан хүний тоо	Too	-	-	60	120	200
7.	3.2.4.Насан туршийн боловсрол төв, нэгжээр дамжуулан иргэдэд монгол бичиг заах сургалтыг үе шаттай хэрэгжүүлэх	Бүх нийтээрээ монгол бичгээрээ унших, бичих, кирилл бичгээрээ алдаагүй бичих чадвар дээшилсэн, монгол бичгээ сурах иргэдийн сонирхол хэрэгцээ ессэн байна.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	Too	-	-	850	1700	2500
Зорилт 3.3 Албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах бэлтгэл хангах									
8.	3.3.1.Төрийн байгууллагын бичиг хэргийн ажилтан болон орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтныг чадваржуулах	Албан хэрэг хөтлөлт, бичгийн чадвар дээшилсэн байна.	Сургалтад хамрагдсан ажилтны тоо	Too	-				
		Албан хэргийг хос бичгээр явуулах бэлтгэл ханган, туршиж эхэлсэн байна.	Хос бичгээр албан хэрэг хөтлөх журмыг туршсан байгууллагын хувь	Xувь	-	-	10	20	30
9.	3.3.2. Монгол хэл, бичгийн зөв бичих дүрэм, журамласан уг зэргийг сайгад байршуулж нийтэд түгээх	Иргэдийн зөв бичих чадвар дээшилсэн байна.	Сайгад байршуулсан мэдээллийн тоо	Too	-	120	240	260	480
Зорилт 4.Монгол хэл, бичгийн судалгаа, сурталчилгааны ажлыг өргөжүүлэх									
10.	3.4.1 Бүх шатны Засаг дарга нар нутаг дэвсгэрийн хэмжээнд үндэсний бичиг	Үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлж, бүх нийтээр монгол бичгээ	Өрнүүлсэн аян арга хэмжээний тоо	Too	-	5	10	15	20

	соёлоо түгээн дэлгэрүүлэх, аян өрнүүлэх, иргэдийг урамшуулах	сурх								
11.	3.4.2.Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд үндэсний бичиг соёлоо сурталчлах, дэлгэрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх	Хэвлэл мэдээллийн байгууллагад монгол бичгийн орчин, хэрэглээ бүрдсэн байна.	Монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлсэн агуултын хувь	Хувь	-	5	10	15	20	
12.	3.4.3.Монгол хэл, бичгийн сургалт сурталчилгааны төв байгуулах	Сургалтын төвтэй болж, сургалтад хамрагдсан иргэдийн тоо ессен байна.	Байгуулсан сургалт сурталчилгааны төвийн тоо	Тоо	-	-	1	-	-	
3.5 "Монгол хэл бичгийн боловсролын чанарыг дээшлүүлэх" зорилтын хурээнд										
13.	3.5.1. Монгол хэл, бичиг, бага ангийн багш нарын мэргэшлийг дээшлүүлэх	Мэдлэг, чадвар дээшилсэн байна.	Зохион байгуулсан сургалт, хамрагдсан багш нарын тоо	Тоо	-	2 400	4 800	6 1200	8 1600	
14.	3.5.2.Багш нарын шилдэг арга зүй, туршлагыг судлах, түгээн дэлгэрүүлэх, сан бүрдүүлэх, урамшуулах	Шилдэг арга зүй, туршлагыг түгээн дэлгэрүүлж, шилдэг багш нарыг урамшуулсан байна	Туршлага судлах түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд оролцсон багш нарын тоо	Тоо	-	25 100	50 200	75 300	100 400	
15.	3.5.3.Сургалтын чанарыг дээшлүүлэхэд идэвх санаачилга гаргасан багш, сургууль, хамт олныг алдаршуулах	Багш, сурагчдын эх хэлний чадвар сайжирч, сургалтын чанарт ахиц гарсан байна	Сургалтын чанарын ахиц	Хувь	34.9	-	44	54	60	

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 8.1. Хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайланг жил бүр тайлагнана.
- 8.2. Хөтөлбөрийн тайлан мэдээг жил бурийн 6, 11 дүгээр сарын 05-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс болон Боловсролын газарт тус тус ирүүлнэ.
- 8.3. Сум, агентлаг, байгууллагын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүн, тайланг жилийн ажлын үнэлгээнд оруулна.
- 8.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний болон хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

---000---

"МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ" ДЭД ХӨТЕЛБЕРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт, арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа				Хариуцах зээн	Хамтран ажиллах байгууллага	Төсөв /сая төгрөгөөр/
				2021	2022	2023	2024			
Зорилт 3.1 Монгол бичгийн орчин бүрдүүлэх;										
1	3.1.1. Териин ёспол, хүндэтгэлийн арга хэмжээнд монгол бичгийг хэрэглэх	Монгол бичгийг хэрэглээ нэмэгдэнэ. Эх хэлээ хайрлах, хамгаалах дээдлэх үзэл төлөвшине.	Хүндэтгэлийн өргөөнд монгол бичгээр бичвэр бичиж байршуулах		+			БГ	ЗДТГ	2.5
2			Шагнал урамшууллыг монгол бичгээр хослуулан бичих	+	+	+	+	Аймаг, сумын ЗДТГ	Байгууллага, аж ахуйн нэгж	0
3	3.1.2. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, танилцуулга, бэлгэ тэмдэг, нэрийн хуудас, зар сурталчилгаа зэргийг кирилл болон монгол бичгээр хослуулан алдаагүй бичих ажлыг зохион байгуулах	Бүх нийтийн монгол бичгийн мэдлэг дээшилнэ. Байгууллага бүр чанарын шаардлага хангасан стандартын хаяг /том, жижиг/-тай болно.	Сум бүр баг, хороо, гудамжны нэр хаяг, бэлгэ тэмдэг /logo/, нутаг дэвсгэрийн зааг дахь самбар зэргийг кирилл болон монгол бичгээр хослуулан бичих	+	+	+	+	Аймаг, сумын ЗДТГ	Албан байгууллага, аж ахуйн нэгж	0
4			Албан байгууллага, аж ахуйн нэгж бүр байгууллагын гадна, дотно хаяг, бэлгэ тэмдэг /logo/, нэрийн хуудас, ажлын баримт бичгийн хавтасны нэрийг монгол бичгээр хаягжуулах	+	+	+	+			0
5			Орон нутагтаяа үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний шошыг монгол бичгээр үйлдэх	+	+	+	+			0
6	3.1.3. Албан байгууллага, аж ахуйн нэгж монгол бичгийн орчин бүрдүүлэх	Монгол бичгийн хэрэглээ, орчин бүрдсэн байна.	Монгол бичиг сурх нам гарын авлага бухий номынсан, булантай болох /Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, Чой.Лувсанжав нарын "Монгол бичгийн хадмал толь" -той болох/	+	+	+	+	Байгууллага, аж ахуйн нэгж	БГ	0
7			Мэдээллийн самбар, зар сурталчилгааг монгол бичгээр бичих, цахим орчин бүрдүүлэх	+	+	+	+			0
8		Монгол бичгийн өргөөтэй болж, хэрэглэгдэхүүнээр хангагдсан байна.	ЕБС-д монгол бичгийн өргөөг тохижуулах, бийрийн бичвэрийн хэрэгсэл, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнээр баяжуулахад дэмжлэг үзүүлэх		+			БГ	Аймаг, сумын ЗДТГ, ЕБС	28.39

Зорилт 3.2. Монгол бичиг сурх, сургах ажлыг эрчимжүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх

9	3.2.1.Албан байгууллага бүр монгол бичгээ ўе шаттай сурх нехцэлийг бүрдүүлэн, цахим хэрэглээг бий болгох	Албан хаагчдын монгол хэл, бичгийн унших бичих чадвар дээшилсэн, монгол бичгийн хэрэглээ орчин бүрдсэн, кирилл бичгээрээ алдаагүй бичдг болсон байна. Хамтын ажиллагаа сайжирна.Цахим бичвэрийн хэрэглээ нэмэгдэнэ.	Байгууллагын гүйцэтгэлийн төвлөлөгөөнд монгол хэл, бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар тусгах, сургалт явуулах едер, цагтай болж, Монгол хэлний багш наартай гэрээ байгуулж, хамтарч ажиллах /аж ахуйн нэгж/	+	+	+	+	Байгууллага, аж ахуйн нэгж	Аймаг сумын ЗДТГ, БГ, ЕБС	0
10			Албан хаагчдын монгол хэл, бичгийн мэдлэгийн судалгаа авч, түвшинг тогтоож, монгол бичгээр унших бичих чадварыг сайжруулах	+	+	+	+	Аймаг, сумын ЗДТГ, БГ	Байгууллага, аж ахуйн нэгж	0
11			Терийн албан хаагчид компьютер, гар утсандaa монгол бичгийн фонд, монгол хэл, монгол бичгийн толиудын application суулгах, түүнийг ашиглаж сурх, хэрэглээ болгох	+	+	+	+	Байгууллага	БГ, ЕБС	0
12	3.2.2.Монгол хэлний зөв бичих дүрэм, монгол бичгийн төле хичээл явуулж, цахим сургалтыг нэмэгдүүлэх	Нийт иргэдийн кирилл бичгээр алдаагүй бичих чадвар дээшилж, монгол бичгээ сурх сэдэл тэмүүлэл бий болж, сурх боломж нехцел бүрдэнэ.	Зөв бичих дурмийн төле хичээл зохион байгуулах	+	+			БГ	Орон нутгийн ТВ	6.0
13			Монгол бичгийн төле хичээл зохион байгуулах	+	+			БГ		6.0
14			Найруулга зүйн төле хичээл зохион байгуулах	+	+			БГ		6.0
15			Монгол бичгийн дасгал ажил, хэлзүйн гарын авлага хэвлүүлэх, нийтийн хүртээн болгох	+	+			БГ	ХоИС	6.08
16			Тод бичгийн гарын авлага, уран зохиолын унших бичиг монгол бичгээр эх бэлтгэн хэвлүүлэх	+	+			БГ	ЕБС	6.6
17	3.2.3 Бийрийн бичвэрийн сургалт зохион байгуулах, дугуйлан хичээллүүлэхэд дэмжилэг үзүүлэх	Өв соёлоороо бахархан, бүтээлийн үзэсгэлэн гаргаж, олон нийтэд сурталчилсан байна	Иргэдэд сургалт зохион байгуулах	+	+	+		БГ	Иргэд	20.0
18			Сурагчдад дугуйлан хичээллэх	+	+	+		БГ	ЕБС	20.0
19			Багш наарт сургалт зохион байгуулах	+				БГ	ЕБС, СӨБ	4.5
20	3.2.4.Насан туршийн боловсрол төв, нэгжээр дамжуулан иргэдэд монгол бичиг заах сургалтыг ўе шаттай хэрэгжүүлэх	Монгол бичгээ сурх иргэдийн сонирхол хэрэгцээ ессеен байна.	Иргэдэд монгол бичиг заах сургалтыг ўе шаттай зохион байгуулах	+	+	+		ЗДТГ, БГ, НТБТ,	Сумын ЗДТГ, НТБТ-ийн нэгж	20.0

21	3.3.1. Терийн байгууллагын бичиг хэргийн ажилтан болон орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтныг чадваржуулах	Албан хэрэг хөтөлт, бичгийн чадвар дээшилсэн байна. Албан хэргийг хос бичгээр явуулах бэлтгэл ханган, туршиж эхэлсэн байна.	ЗДТГ, ИТХ-ын нарийн бичгийн дарга, терийн болон терийн бус байгууллагудын бичиг хэргийн ажилтам болон орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтныг чадваржуулах кирилл бичгийн зөв бичих дүрмийн болон монгол бичгийн цахим бичвэрийн сургалт зохион байгуулах	+	+	+	3ДТГ, БГ	Аймаг, сумын ИТХ, ЗДТГ, Байгууллага, аж ахуйн нэгж
22			Терийн байгууллага албан хэрэгээ хос бичгээр зэрэгцүүлэн бичиж турших	+	+	+		2.0
23	3.3.2. Монгол хэл, бичгийн зөв бичих дүрэм, журамласан үг зөргийг сайтад байршуулж нийтэд түгээх	Иргэдийн зөв бичих чадвар дээшилсэн байна.	Цахим орчинд монгол бичиг, зөв бичих дүрэм, журамласан үгийг түгзэх, пэйж хуудас ажиллуулах	+	+	+	БГ	ЕБС
Зорилт 3.3 Нийт дүн								10.00

Зорилт 3.4. Монгол бичгийн судалгаа, сурталчилгааны ажлыг өргөжүүлэн, түгээн дэлгэрүүлэх

24			"Эх хэл бидний бахархал" үндэсний бичиг үсгийн баярыг тусгай удирдамжаар тэмдэглэх	+	+	+	+	
25	3.4.1 Бүх шатны Засаг дарга нар нутаг дэвсгэрийн хэмжээнд үндэсний бичиг соёлоо түгээн дэлгэрүүлэх, аян өрнүүлэх, иргэдийг урамшуулах	Үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлж, бүх нийтээр монгол бичгээ сурах	Байгууллага, аж ахуйн нэгжийн дунд "Монгол бичиг бидний бахархал" уралдаан зохион байгуулах,		+	+	+	ЗДТГ, БГ, Нийтийн номын сан
26			"Ховдын сайхан бичигтэн" уралдаан зохион байгуулах	+	+	+	+	
27			"Монгол бичгийн тэргүүний үншигч" уралдаан зохион байгуулах	+	+	+	+	
28			Хөтөлбөрийг хэргажуулэхад идэвх санаачилгатай ажилласан сум, байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, багш, суроч, терийн албан хаагч, гэр бүлийг жил бүр шагнаж урамшуулах	+	+	+	+	Аймаг, сумын ЗДТГ
29	3.4.2 Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийд үндэсний бичиг соёлоо сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хэрэглээг	Хэвлэл мэдээллийн байгууллагад монгол бичгийн орчин, хэрэглээ бурдсан байна.	Орон нутгийн сонин хэвлэл нүүр хуудас болон тусгай буланг тогтмол монгол бичгээр гарах.	+	+	+	+	Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллага
30			Орон нутгийн телевизүүд дэлгэцийн бичвэр, нэвтрүүлгийн нэрийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн бичих ажлыг зохион байгуулах	+	+	+	+	БГ
								0

31	нэмэгдүүлэх		Байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, үндэсний бичиг, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, сурталчлах	+	+	+	+		Байгууллага, аж ахуйн нэгж	0
32	3.4.3 Монгол хэл, бичгийн сургалт сурталчилгааны төв байгуулах	Сургалтын төвтэй болж, сургалтад хамрагдсан иргэдийн тоо ессен байна.	Монгол хэл, бичгийн сургалт сурталчилгааны төв байгуулах		+			ЗДТГ, БГ		10.0
33			Монгол бичгийн албан бус сургалт явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг хөхиүүлэн дэмжих, сурталчлах		+	+	+	ЗДТГ, БГ	Байгууллага, аж ахуйн нэгж	15.0
Зорилт 3.4 Нийт дүн										75.4

3.5 “Монгол хэл, бичгийн боловсролын чанарыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд

34	3.5.1 Монгол хэл, бичиг, бага ангийн багш нарын мэргэшлийг дээшлүүлэх	Мэдлэг, чадвар дээшилсэн байна.	Мэргэжлийн зөвлөх багш нараар онол, арга зүйн сургалт зохион байгуулах	+	+	+	+	БГ	ЕБС	12.00
35			Тод бичгийн сургалтад хамруулах		+			БГ	ХоИС, ЕБС	1.50
36			УБ хот, бусад аймгийн туршлага судлах ажлыг зохион байгуулах		+		+	ЗДТГ, БГ	ЕБС	8.55
37			Багш нарын дунд хетэлбэр, хэрэглэгдэхүүн, ур чадварын цахим уралдаан зохион байгуулж, шилдэг арга зүй, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, 2 жилд 1 удаа зөвлөгөөн зохион байгуулах		+	+	+	ЗДТГ, БГ	ЕБС, СӨБ	11.4
38	3.5.2. Багш нарын шилдэг арга зүй, туршлагыг судлах, түгээн дэлгэрүүлэх, цахим сан бурдүүлэх, урамшуулах	Шилдэг арга зүй, туршлагыг түгээн дэлгэрүүлж, шилдэг багш нарыг урамшуулсан байна.	Улсын чанартай олимпиадад “Хүмүүн бичиг” сайхан бичигтэн, “Ертөнц” төв монгол бичгийн анги нийтийн улсын уралдаан/манлайлсан багш нарыг урамшуулах		+	+	+	ЗДТГ, БГ	ЕБС Хэлний салбар зөвлөл	4.0
39			Шинэ санаачилга гарган ажилласан баг хамт олныг шалгаруулж, урамшуулах		+	+	+	ЗДТГ, БГ	ЕБС, Хэлний салбар зөвлөл	3.2
40			Байгууллагуудтай байгуулсан гэрээгээ чанартай биелүүлсэн багийг шалгаруулж урамшуулах		+	+	+	ЗДТГ, БГ	Байгууллага, аж ахуйн нэгж, хэлний зөвлөл	4.0
41	3.5.3. Сургалтын чанарыг дээшлүүлэхэд идэвх санаачилга гаргасан багш, сургууль, хамт олныг алдаршуулах	Багш, сурагчдын эх хэлний чадвар сайжирч, сургалтын чанарт ахиц гарсан байна.	ЕБС, цэцэрлэг бур монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлэх төлөвлөгөө боловсруулан үр дүнг тооцож ажиллах	+	+	+	+	ЕБС, СӨБ	БГ	0
42			Үндэсний өв соёлоо тээгч, түгээгч уралдаанд анги нийтээрээ оролцох		+	+	+	БГ	ЕБС	0

43		"Үсэглэлийн хаан", "Тунгаамал", "Алтан хонх", "АХА" зэрэг нэвтрүүлгийг аймгийн хэмжээнд зохион байгуулж, ТВ нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэх	+	+	+	БГ	ЕБС Хэлний салбар зөвлөл	6.4
44		Хэлц хэлний дархлаа- танин мэдэхүйн нэвтрүүлэг	+		+	БГ	ЕБС, Хэлний салбар зөвлөл	1.0
45		"Эх хэл эрдэнэсийн сан"- нэвтрүүлэг	+	+		БГ	ЕБС, Хэлний салбар зөвлөл	1.0
46		Бага анги, монгол хэлний багш нарын нэрэмжит олимпиадыг зохион явуулах	+	+	+	БГ	ЕБС, Хэлний салбар зөвлөл	6.8
47		Суралцагчдын эх хэлний мэдлэгийн чанарын ахицаар багш, анги хамт олныг урамшуулах /3.4.7.9-р анги/	+	+	+	БГ	ЕБС Хэлний салбар зөвлөл	30.0
48		Хөгжлийн онцлогтой хүүхдийн эх хэлний чадварыг сайжруулахад багш, эцэг эхэд зориулсан зөвлөмж, гарын авлага, боловсруулан түгээх	+			БГ	ЕБС, СӨБ	2.0
		Бусад үйл ажиллагааны зардал	+					1.0
							Зорилт 3.5 Нийт дүн	92.85
	Нийт		5.8	151.07	80.35	67.1		304.32

---Оо---